

**ХОНЬ, ТЭМЭЭНИЙ НООС БЭЛТГЭЖ, ҮНДЭСНИЙ  
ҮЙЛДВЭРТ ТУШААСАН МАЛЧИН, МАЛ БҮХИЙ  
ЭТГЭЭДЭД МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Боловсруулах үндэсний үйлдвэр, цех (цаашид “боловсруулах үйлдвэр” гэх)-д хонь, тэмээний ноос (цаашид “ноос” гэх) бэлтгэн тушаасан малчин, мал бүхий этгээд (цаашид “малчин” гэх)-д мөнгөн урамшуулал олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнахтай холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна. Тайлбар: “мал бүхий этгээд” гэдэгт малчны хоршоо, өмчийн бүх хэлбэрийн цөм сүргийн аж ахуйг ойлгоно.

1.2. Боловсруулах үйлдвэрт ноос бэлтгэж тушаасан малчинд өмнөх жилийн эцсийн мал тооллогын А данс дахь малын тоо, үүлдэрлэг байдал, ашиг шим, хонины ноосыг MNS 0033:2007 бэлтгэлийн стандарт, тэмээний ноосыг MNS 0036:2015 бэлтгэлийн стандарт хангасан нөхцөлд дор дурдсан урамшуулал олгоно:

1.2.1. хонь болон тэмээний нэгдүгээр зэргийн ноосны кг тутамд 2000 төгрөг;

1.3. Боловсруулах үйлдвэр гэдэг нь хялгас ялгах, самнах, ээрэх, нэхэх эсвэл сүлжих иж бүрэн техник технологи бүхий дамжлагуудтай эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон ангилан ялгах, угаах, эсгийлэх техник технологи бүхий дамжлагуудтай угаасан ноосоор эсгий, эсгий бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байна.

1.4. Боловсруулах үйлдвэрт ноос бэлтгэж тушаасан малчинд мөнгөн урамшуулал олгохтой холбогдох харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж болон энэ журмыг харьяалах нутаг дэвсгэртээ сурталчлах, энэ чиглэлээр малчдад сургалт явуулах ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, малчдын хоршоо, холбоотой хамтран зохион байгуулна.

1.5. Боловсруулах үйлдвэрт жилд шаардлагатай тоо, хэмжээний ноосонд мөнгөн урамшуулал олгоно. Боловсруулах үйлдвэрт шаардлагатай ноосны тоо хэмжээг Зохицуулах ажлын хэсэг жил бүр тогтоож нийтэд зарлана.

**Хоёр. Урамшуулалд хамрагдах малчин болон ноосон бүтээгдэхүүн  
үйлдвэрлэгчдийн холбоо, Зохицуулах ажлын хэсэг, боловсруулах  
үйлдвэрт тавих шаардлага**

2.1. Урамшуулалд хамрагдах малчин дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. малаа малын бүртгэлийн нэгдсэн санд бүртгүүлж, мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх болон арьсны шимэгчээс сэргийлэх арга хэмжээнд технологит хугацаанд тогтмол хамруулсан, эрүүл болохыг баталгаажуулсан тодорхойлолтыг гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс авсан байх;

2.1.2. энэ журмын 1.2-т заасан шаардлагыг хангасан ноосыг төрлөөр нь ангилан 50-100 кг-аар савлаж бэлтгэх;

2.1.3. энэ журмын 3.4-т заасан баримтад өөрийн харилцах арилжааны банк (цаашид “арилжааны банк” гэх)-ны нэр, дансны дугаарыг бичиж, малчин өрхийн баталгааны тэмдгээр баталгаажуулна. Малчин нь өрхийн баталгааны тэмдгийг бусдад ашиглуулахгүй байх үүрэг хүлээнэ.

2.2. Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо (цаашид “холбоо” гэх) дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1. Ноосон түүхий эд бэлтгэх боловсруулах үйлдвэрийн жагсаалтын саналыг жил бүрийн 4 дүгээр багтаан Зохицуулах ажлын хэсэгт хүргүүлэх;

2.2.2. бараа материалын тооцооны баримт (цаашид “баримт” гэх)-ын загварыг Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 дүгээр хамтарсан тушаалаар баталсан загварт нийцүүлэн боловсруулж, холбогдох мэдээлэл, ялгах тэмдэглэгээг тусгасан байх;

2.2.3. бэлтгэлийн төлөөлөгч, Сумын Засаг даргатай гурвалсан гэрээ байгуулж, итгэмжлэл олгох;

2.2.4. малчдын хоршоо, итгэмжлэгдсэн төлөөлөгч нь өөрийн бэлтгэсэн ноосонд чанарын тордолт хийх, хэвийн хорогдлыг хариуцах, өөрийн худалдан авсан түүхий эдийнхээ хадгалалт тээвэрлэлтийн явцад гарсан чанарын өөрчлөлтийн улмаас гарах хохирлыг бүрэн хариуцах ба урамшууллын падаан бичихгүйгээр ноос бэлтгэхийг малчдын хоршоо, итгэмжлэгдсэн төлөөлөгчид хориглох;

2.2.5. энэ журмын 2.2.2-т заасан баримтыг мөн журмын 1.3-т заасан боловсруулах үйлдвэрт хуваарилах санал боловсруулж Зохицуулах ажлын хэсэгт хүргүүлэх;

2.3. Ноосыг стандартын дагуу бэлтгэж, тушаах талаар малчдад сургалт явуулах чиг үүргийг боловсруулах үйлдвэр, аймаг, сумын Засаг дарга, тухайн орон нутгийн малчдын хоршоо, холбоо, итгэмжлэгдсэн төлөөлөгч хариуцан хэрэгжүүлнэ.

2.4. Боловсруулах үйлдвэр нь тухайн жилд худалдаж авсан ноосоор эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн тухай мэдээллийг Мал хамгаалах санд болон хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал тутамд, Зохицуулах ажлын хэсэгт хагас жил тутамд хүргүүлж байна.

2.3. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр Зохицуулах ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн дүрмийг баталж ажиллуулна. Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга орон тооны, үйл ажиллагаа нь байнгын байна.

2.4. Зохицуулах ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх) дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.4.1. Хонь, тэмээнээс бэлтгэж буй ноосон түүхий эд болон хөнгөн үйлдвэрийн чиглэлээр баримталж буй төр, засгийн бодлогыг ноосон түүхий эд бэлтгэлийн үйл ажиллагаанд тусгах;

2.4.2. Боловсруулах үйлдвэрийн төрөл, ангиллын жагсаалтыг жил бүрийн 5 дугаар сард багтаан нийтэд мэдээлэх;

2.4.3. Холбооноос ирүүлсэн бараа материалын тооцооны баримтыг боловсруулах үйлдвэрт хуваарилах, олгох саналыг авч хэлэлцэн, эцсийн шийдвэрийг гаргах, баримтын зарцуулалтын тооцоонд хяналт тавьж ажиллах;

2.4.4. Бараа материалын тооцооны баримтыг олгохдоо тухайн бүс нутаг, газарзүйн байршлаас хамаарсан хонь, тэмээний ноосны өөрийн өвөрмөц чанарыг тухайн үйлдвэрийн технологи, боловсруулалтын шат дамжлага зэрэгтэй уялдуулан тооцох, Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан түүхий эдээ бэлтгэсэн байдлыг харгалзан үзэх;

2.4.5. энэ журмын 2.4.2-д зааснаас бусад үйлдвэрт баримт олгохгүй;

2.4.6. Бэлтгэлийн төлөөлөгч малчнаас ноос худалдан авахдаа зах зээлийн үнийг баримталж байгаа эсэх, ноосыг өрсөлдөөний журмаар авах нөхцлийг бүрдүүлсэн байдалд хяналт тавих;

## **Гурав. Урамшуулал олгох**

3.1. Урамшууллын мөнгийг Монголбанкинд “Малчин” данс нээж, Монголбанкнаас тухайн малчны арилжааны банк дахь дансанд шилжүүлэх замаар олгоно.

3.2. Малчин нь арилжааны банкинд өөрийн нэр дээр данс нээсэн байна.

3.3. Энэ журмын 3.2-т заасан арилжааны банкны салбар нь дансны мэдээллээр нэгдсэн жагсаалт гаргаж холбогдох төв банкинд, уг төв банк нь Монголбанкинд тус тус хүргүүлнэ.

3.4. Боловсруулах үйлдвэр нь малчдаас ноос худалдан авахдаа Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан захиалга өгнө.



илэрсэн тохиолдолд Монголбанк урамшууллын мөнгийг шилжүүлэхгүй бөгөөд холбогдох мэдээллийг арилжааны банк болон Мал хамгаалах сангаас шаардана.

3.20. Арилжааны банк нь Монголбанкнаас шаардсаны дагуу банкны нэр, дансны дугаар, овог, нэр, регистрийн дугаарын талаарх шинэчилсэн мэдээллийг ажлын 3 хоногт багтаан хүргүүлнэ.

3.21. Энэ журмын 3.19-д заасан материалд байгаа зөрчлийн талаарх мэдээлэл болон уг зөрчлийг хэрхэн арилгах мэдэгдлийг Мал хамгаалах сангаас холбогдох аймаг, нийслэлийн Хөдөө аж ахуйн газарт, Хөдөө аж ахуйн газар нь сум, дүүргийн Мал эмнэлэг, үржлийн тасагт ажлын 3 хоногт багтаан тус тус хүргүүлнэ.

3.22. Сум, дүүргийн Мал эмнэлэг, үржлийн тасаг энэ журмын 3.21-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан зөрчлийг арилгаж, холбогдох материалыг аймаг, нийслэлийн Хөдөө аж ахуйн газраар дамжуулан Мал хамгаалах санд хүргүүлнэ.

3.23. Мал хамгаалах сан нь энэ журмын 3.22-д заасан хугацаанд багтаан ирүүлсэн материалыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан Монголбанкинд хүргүүлнэ.

3.24. Монголбанк нь арилжааны банк болон Мал хамгаалах сангаас ирүүлсэн мэдээллийг хүлээн авснаас хойш энэ журмын 3.18-т заасан хугацаанд тухайн малчны арилжааны банк руу мөнгийг шилжүүлнэ.

### **Дөрөв. Урамшуулал олгохоос татгалзах үндэслэл**

4.1. Дараах тохиолдолд малчинд урамшуулал олгохгүй:

4.1.1. ноос тушаасан боловсруулах үйлдвэр нь энэ журмын 2.4.2-т заасан жагсаалтад хамрагдаагүй бол;

4.1.2. энэ журмын 3.22-д заасан хугацаанд холбогдох мэдээллийг шинэчлэн ирүүлээгүй бол;

4.1.3. энэ журмын 4.2-т заасан боловсруулах үйлдвэрт ноосоо тушаасан бол;

4.1.4. энэ журмын 1.3-т зааснаас бусад үйлдвэрт ноосоо тушаасан бол;

4.1.5. энэ журмын 2.1.1 дэх заалтыг хангаагүй бол;

4.2. Мал хамгаалах сан нь энэ журмын 6.3.2-т заасан тайлан, мэдээлэл ирүүлээгүй боловсруулах үйлдвэрийг нийтэд мэдээлж, үйлдвэрийн нэрийг хөдөө аж ахуйн болон хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, холбоонд тус тус хүргүүлнэ.

### **Тав. Урамшуулал олгох хөрөнгийг төлөвлөх, тайлагнах**

5.1. Аймаг, нийслэлийн Хөдөө аж ахуйн газар нь жилийн эцсийн мал тооллогын дүн, сүргийн эргэлтэд үндэслэн харьяа нутаг дэвсгэртээ дараа жилд бэлтгэх боломжтой хонь, тэмээний ноосны хэмжээ, нутаг дэвсгэртээ байгаа боловсруулах үйлдвэрийн жагсаалт, тэдгээрийн хүчин чадлыг сум, дүүрэг тус бүрээр гаргаж, жил бүрийн II улиралд багтаан Мал хамгаалах санд хүргүүлнэ.

5.2. Холбоо нь боловсруулах үйлдвэр тус бүрийн дараа жил худалдан авах ноосны хэмжээг нэр, төрлөөр нь гаргуулж нэгтгэн, жил бүрийн II улиралд багтаан Мал хамгаалах санд хүргүүлнэ.

5.3. Мал хамгаалах сан нь энэ журмын 5.1, 5.2-т заасан мэдээллийг харьцуулан судалж, дараа жил боловсруулах үйлдвэрт ноосоо тушаах малчинд олгох урамшууллын хэмжээг төлөвлөн хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад тусгуулах санал тавина.

5.4. Урамшуулал олгох үйл ажиллагааг дор дурдсаны дагуу тайлагнана:

5.4.1. Монголбанк нь урамшууллын мөнгө олгож байгаа арилжааны банктай тооцоо нийлж, тайланг тухайн жилийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Мал хамгаалах санд хүргүүлэх;

5.4.2. Төрийн сангаас ноосны урамшуулалд олгосон санхүүжилт арилжааны банкинд шилжүүлэх мөнгөнөөс илүү гарсан тохиолдолд үлдэгдэл мөнгийг Төрийн сан дахь Мал хамгаалах сангийн дансанд буцаах;

5.4.3. Мал хамгаалах сан нь тухайн онд урамшуулалд хамрагдсан малчдын бүртгэл, хөрөнгийн зарцуулалтын талаарх мэдээ, тайланг дараа оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

5.4.4. Мал хамгаалах сан нь жил бүр урамшуулалд шаардагдах хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн тайланд дараа оны II улиралд багтаан аудит хийлгүүлэх;

5.4.5. Мал хамгаалах сан нь урамшуулал олгох асуудлыг төлөвлөх, олгох асуудалтай холбоотой материал, мэдээлэл, тайланг архивын нэгж болгон хадгалах.

### **Зургаа. Хяналт тавих**

6.1. Боловсруулах үйлдвэрт ноос бэлтгэж тушаасан малчинд мөнгөн урамшуулал олгох харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, энэ журам болон эрх бүхий байгууллагаас гаргасан бусад шийдвэрийн хэрэгжилтэд сум, дүүргийн Засаг дарга хяналт тавина.

6.2. Улсын хэмжээнд энэ журмын хэрэгжилтэд хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

6.3. Боловсруулах үйлдвэр худалдан авсан ноосоороо эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа эсэхийг дараах байдлаар хянана:

6.3.1. холбооны зүгээс боловсруулах үйлдвэр худалдан авсан ноосоороо эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа явцтай улирал бүр танилцаж, тайланг дараа оны 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор хөдөө аж ахуй болон хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мал хамгаалах сангийн төлөөлөл орсон Зохицуулах ажлын хэсэгт хүргүүлж хэлэлцүүлэх;

6.3.2. боловсруулах үйлдвэр тухайн жилд хүлээн авсан ноосоор эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж худалдсан орлогын албан татвар төлсөн тухай аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн татварын тайланг болон ажлын байр нэмэгдүүлсэн, хадгалсныг харуулсан харьяа нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулсан нийгмийн даатгалын сар бүрийн тайланг энэ журмын 6.3.1-д заасан тайланд хавсаргах.

### **Долоо. Хариуцлага**

7.1. Боловсруулах үйлдвэр малчны нийлүүлсэн ноосны хэмжээ, чанар, ангиллын талаар буруу мэдээ ирүүлсэн эсхүл хуурамч баримт бүрдүүлж өгсөн бол энэ журамд заасан хугацаанд холбогдох мэдээллийг ирүүлээгүйгээс бусдад учирсан хохирлыг уг үйлдвэр бүрэн хариуцна.

7.2. Энэ журмын 2.1.1-д дурдсан тодорхойлолтыг холбогдох журмыг зөрчиж, хуурамчаар үйлдэж олгосон хувийн мал эмнэлгийн нэгжид холбогдох хуулинд тусгагдсан хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

7.3. Мал хамгаалах сан урамшуулалтай холбогдох мэдээллийг цахим бүртгэлийн системд буруу оруулсан, засварласан тохиолдолд учирсан хохирлыг тухайн сан бүрэн хариуцаж арилгана.

7.4. Ноосны урамшууллын мөнгийг арилжааны банк дахь малчны данс руу шилжүүлэхэд алдаа, зөрчил гаргасан бол учирсан хохирлыг арилжааны банк бүрэн хариуцаж арилгана.

7.5. Боловсруулах үйлдвэр ноосонд анхан шатны (угаах) боловсруулалт хийж экспортолсон бол Мал хамгаалах сан нь урамшууллын мөнгийг нөхөн төлүүлж, учирсан хохирлыг арилгуулна.

7.7. Бэлтгэлийн төлөөлөгч нь малчнаас худалдан авсан ноосыг үндэсний боловсруулах үйлдвэрт тушаагаагүй бол тухайн малчинд олгох урамшууллыг бэлтгэлийн төлөөлөгч хариуцаж, барагдуулна.

7.8. Боловсруулах үйлдвэр энэ журмын 3.8-т заасныг зөрчиж баримтыг буруу, ташаа үйлдсэн нь тогтоогдвол тухайн үйлдвэрт тушаасан ноосонд олгосон урамшууллын зөрүүг нөхөн төлүүлнэ.

7.9. Энэ журмын 3.11-д заасан мэдээллийг буруу ташаа гаргасан сум, дүүргийн Мал эмнэлэг, үржлийн тасгийн ажилтан, сум, дүүргийн Засаг даргад Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

7.10. Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, сум, дүүргийн Засаг даргын жилийн ажлыг дүгнэхдээ энэхүү журмын хэрэгжилтийг хангаж, ноосон түүхийг эдийг Үндэсний үйлдвэрт тушаасан байдлыг нэг шалгуур үзүүлэлт болгож авч үзнэ.

7.11. Энэхүү журмыг даган мөрдөж малчин нь Үндэсний үйлдвэрт ноосон түүхий эдээ тушаавал төрөөс мал аж ахуйн салбарт үзүүлж буй төрөл бүрийн үйлчилгээ, тусламж, дэмжлэгэнд хамруулах давуу тал болгож авч үзнэ.

-----o0o-----